БАТЛАВ.
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАТБААТАР

2025 оны 08 сарын 05-өдөр

ТТБ7815 9103643

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН Б, В БЛОКД БАЙРЛАХ ХҮҮХЭД, ХҮҮХДИЙН ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭНИЙ ТАСГИЙН АГААР СЭЛГЭЛТИЙН ЗАСВАРЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗУРГИЙН ДААЛГАВАР

2025 оны 08 дугаар сарын 04 Багануур дүүрэг

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А20 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн байгууллагын агаар сэлгэлтийн системийг сайжруулах ажил”, (Улаанбаатар хот) төсөл арга хэмжээний хүрээнд
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	Багануур дүүрэг. 1 дүгээр хороо. Наран хороолол Эрүүл мэндийн төв, 10 блок барилгын нийт талбай 26125 м^2 үүнээс үндсэн барилга 3 давхар, 5 блок (зоорьтой)18800 м^2
3	Зориулалт, хүчин чадал	Эрүүл мэндийн байгууллагын агаар сэлгэлтийн системийг сайжруулах төслийн хүрээнд Эрүүл мэндийн төвийн хүүхэд, хүүхдийн эрчимт эмчилгээний тасаг. Үндсэн барилгын Б, В блокын 2-р давхарт 1362,7 м^2 ,таазны өндөр 2,9 м. Барилгын нийт өндөр -12,60м
4	Төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.
5	Ажлын зураг төслийн иж бүрдэл	<u>Зургийн иж бүрдэл</u> • Нүүр хуудас /батлагдах/ • Байршлын схем • Тайлбар бичиг, зургийн жагсаалт • Хэмжилтийн байгуулалт • Засварын ажлын байгуулалт, ажлын зураг • Заслын ажлын тодорхойлолт • Засварын төсөв <u>Зураг төсөлд тавигдах шаардлага:</u> Зураг төслийн баримт бичиг 1 эх хувь, 2 хуулбар хувь боловсруулна. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө. Ажлын зурагт одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг оптолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, ашиглагч байгууллагатай зөвшилцсөн байх шаардлагатай.
6	Зураг төсөл боловсруулах үе шат	2 үе шаттай. Үүнд: - Зургийн даалгавар боловсруулах - Засварын зураг төсөл боловсруулах

7	Ажлын зураг төслийн байгууллага	Засварын ажил нь "Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх" (БНбД 31-22-21)-ийн дагуу зураг төсөл боловсруулна. Бүх дотор заслын материал нь галын аюулгүй байдлын БНбД 21-01-02-ын шаардлагад нийцсэн, эрүүл ахуйн шаардлага хангасан материал байна. Барилгын хийц бүтээц өөрчлөх, хана нураах ажлыг холбогдох хууль, дүрэм журмын дагуу тооцож зураг төсөвт тусгах.
8	Захиалагч байгууллага	- Нийслэлийн Эрүүл Мэндийн газар - Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв
9	Засвар хийгдэх ажлууд	- 35 ортой хүүхдийн тасаг болон 6 ортой хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн өрөөний зориулалтаас хамаарч одоо мөрдөгдөж байгаа БНбД, стандартын шаардлагатай нийцүүлж, агаар сэлгэлтийн систем шинээр болон шинэчлэн төлөвлөх, - Агаар сэлгэлтийн систем төлөвлөхдөө агаар сэлгэлтийн тооцооны үнэдсэн дээр одоо байгаа сорох системийг шинэчлэн засварлах - Агаар сэлгэлтийн системийг шинээр хийх, шинэчлэн засвар хийхэд дагалдан гарах шаардлагатай засварын ажлуудыг хийх
10	Онцгой нөхцөл	Эмнэлэг 1988 онд ашиглалтад орсон 3 давхар 5 блок барилгаас бүрдсэн. Ашиглалтад орсноос хойш их засвар огт хийгдээгүй, сорох зориулалтын агаар сэлгэлтийн систем элэгдэлд орж муудсан, сэлбэг хэрэгсэл олдоц муу, засвар үйлчилгээ хийх боломжгүй байна. Агааржуулалтын систем нь тухайн хэсгийн агааржуулалтын даралтыг зохицуулах, шаардлагатай хэсэгт агаарыг сорох/цэвэршүүлэх хэлбэрээр ажиллах ёстой. Тиймээс зурагт төсөвт дараах онцгой нөхцлийг тусгах шаардлагатай: - Тусгай зориулалтын HEPA болон химийн шүүлтүүртэй агааржуулалтын төхөөрөмж төлөвлөх - Нэг чигт агаар урсгал бүхий системээр зохион байгуулах - Гадна агаарын чанарын хяналт, агаарын урсгалын хурд, даралтыг тооцох - Сэрэмжлүүлгийн болон аваарын системтэй уялдуулах (жишээ нь хийн мэдрэгч, дохиололтой болох) - Хяналт болон аюулгүй байдлын шалгалт тогтмол хийх боломжтой байхаар төлөвлөх Эдгээр нөхцөл шаардлагыг бүрэн хангаснаар эмнэлгийн аюулгүй байдал, халдвараас сэргийлэх, эмнэлгийн туслам үйлчилгээний чанар үр дүнд эергээр нөлөөлнө. <u>Засварын ажилд тавигдах шаардлага:</u> • Засварын зураг төслийг газар дээр нь ирж хэмжилт хийж, орчны нөхцөл байдал болон инженерийн шугам сүлжээний одоогийн байдал хэтийн төлөвлөлттэй уялдуулан, боловсруулах; • Гүйцэтгэгч нь захиалагч, ашиглагчтай ажлын тоо хэмжээний талаар зөвшилцөж боловсруулах; • Зураг төслийн ажлыг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, тушаал, заавар, БНбД, стандартын дагуу боловсруулна. • Засварын ажил хийхэд дагалдан гарах нөхөн сэргээх, зардал болон технологийн шаардлагатай ажлын тоо хэмжээг төсөлд тусган хийж гүйцэтгэх

		• Засварын ажилд ашиглагдах материалыг сонгохдоо, орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлсэн шинэ чанартай тоног төхөөрөмжийн үнийг зах зээлийн судалгаа хийж төсөвт тооцох
11	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<u>Монгол Улсын хуулиуд:</u> • Хот байгуулалтын тухай хууль • Галын аюулгүй байдлын тухай хууль • Барилгын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ • Эрүүл мэндийн тухай хууль • Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуулийн 24.1.1, 24.1.2 • Эрчим хүчний тухай хууль; • Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль; • Бусад холбогдох хууль тогтоомжууд <u>Төсөл, хөтөлбөрүүд:</u> • Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага; • Засгийн газрын 2017 оны 347 дугаар тогтоолоор баталсан “Багануурын 2030 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” <u>Норм, нормативууд:</u> • Эмнэлгийн зориулалттай барилга төлөвлөх БНбД 31-22-21 • Халаалт, агаар сэлгэлт ба кондинционер /БНбД41-01-11/ • Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм / БНбД 21.02.02/ • Цахилгаан байгууламжийн дүрэм (БД 43-101-03) • Автоматжуулалтын систем (БНбД 3.05.07-90) • Тоног төхөөрөмж дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт /БНбД41-03-99/ • Заслын ажил /БНбД31-10-05/ • Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм • Бусад холбогдох норм, дүрэм, заавар <u>Холбогдох стандартууд:</u> • Өрөөний бичил уур амьсгалын үзүүлэлт,MNS5825:2007 • “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй, Ажлын байрны орчин,эрүүл ахуйн шаардлага” MNS4990:2000 • “Ажлын байрны бичил цаг уурын эрүүл ахуйн хэмжээ” MNS12.013-91 • “Ажлын байрны хүчдэлийн түвшин” MNS 12.097-91,MNS 126098-91. MNS 126101-091 • Уур, ус тусгаарлагч материал UCS 1503C:2020 • Заслын материалд тавигдах ерөнхий шаардлага UCS 1506C:2020 <u>Холбогдох дүрэм, журмууд:</u> • Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм (Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол) • Барилгын захиалагчийн дүрэм (Засгийн газрын 2017 оны 170 дугаар тогтоол, 2018 оны 316 дугаар тогтоол нэмэлт, өөрчлөлт) • Барилгын ажилд зураг төсөл зохиогчийн хяналт тавих дүрэм (Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 178 дугаар тушаал)

12	Эдийн засгийн тооцоо, төсөв	Төсвийг ESTIMATOR-PRO программ болон түүнтэй ижил цалинг дундаж зэргээр тооцдог зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно. Ажилбаруудыг хэсэг хэсгээр болон нэгтгэсэн байдлаар хяналтын төсөв бодож, барилгын хөгжлийн төвийн зураг төслийн магадлал хийлгэж баталгаажуулах шаардлагатай.

ХЯНАСАН:
ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН Д.МӨНГӨНЦАЦРАЛ

БОЛОВСРУУЛСАН:
НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТАСГИЙН ЭРХЛЭГЧ Т.АЛТАНЧИМЭГ